

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ

20.17 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 03

Ар Жаргалант

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг дарга Пүрэвдорж овогтой Алтангэрэл (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас "Сэнжит бураат" нэртэй бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч Баярсайхан овогтой Оргилсайхан нар (цаашид хамтад нь "Талууд" гэх)- дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 20.17 оны 02 дугаар сарын 11-ны өдөр энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Норовлин сум (дүүрэг)-д байгуулав

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Норовлин сум(дүүрэг)-ийн Жаргалант багийн нутаг "Шалз-4" нэртэй газарт орших уртраг 112, 18, 59,19 өргөрөг 48, 38, 41,74 уртраг 112, 19, 4,92 өргөрөг 48, 38, 43,14 уртраг 112, 19, 11,65 өргөрөг 48, 38, 31,03 уртраг 112,19, 5,92 өргөрөг 48, 38, 29,63 солбилцол бүхий 4,48 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 1/нэг жилийн хугацаагаар Жонш ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхлэнэ. Тухайн жилд ашиглах талбайн хэмжээ _____

Жич Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөг үндэслэн тухайн жилд ашиглах газрын хэмжээг тодотгоно

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна

Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум, дүүргийн Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүлээнэ

2.1.1. Бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлийг тогтоох.

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дауу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхайн эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах

2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах

2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих.

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

- 3.1 Бичил уурхай эрхлэгч этгээд дараах дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ
 - 3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах.
 - 3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах
 - 3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах.
 - 3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх.
 - 3.1.5. байгаль орчныг хамгаалах хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх.
 - 3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
 - 3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах.
 - 3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх
 - 3.1.9. үйл ажиллагаандаа химиний хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх
 - 3.1.10. иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтанд орсон бичил уурхай уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах
 - 3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах *1000000000* төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дараахь дансанд төвлөрүүлэх. Нөхөн сэргээлтийн 50 хувиин зардал байршуулах данс 100181353400
 - 3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах
 - 3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх
 - 3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах
 - 3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.
- 3.2. Бичил уурхай эрхлэгч нөхөрлөл нь жил бүр сумын ИТХ-д тайлангаа тавьж үнэлэлт, дүгнэлт авах.
- 3.3. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах

Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

- 4.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тул уурлан хамтарч ажиллана
- 4.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохиролыг барагдуулах үүрэгтэй. Сум дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохиролыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана
- 4.3. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж аймаг нийслэлийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан таилагнана

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1 Талууд **гэрээтэй** холбоотой үүссэн аливаа маргаант асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2 Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль Зөрчлийн тухай хууль болон холбогдох журам дүрмийн тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээ хүчин төгөлдөр болох

6.1. Энэхүү гэрээ нь 20 ¹⁹ оны ⁰⁴ сарын ¹¹ өдрөөс 20 ²⁰ оны ⁰² сарын ¹¹ өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ

6.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно

6.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувииг хадгална

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ

7.2 Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно

Найм. Гэрээний нэмэлт

8.1 Нийгмийн даатгалын шимтгэл 388800 төгрөг

8.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 345600 төгрөг

8.3 Хүн амын орлогын албан татвар 477000 төгрөг

8.4 Ус ашиглалтын татвар _____ төгрөг

8.5 Газар ашиглалтын төлбөр _____ төгрөг

8.6 ТББ-ын дундын санд _____ төгрөг

Жич: Ус ашиглалт болон газар ашиглалтын төлбөр хураамжийг ажил эхлэх явцад Ус ашиглах дүгнэлт, Газар ашиглах гэрээгээр зохицуулна

Гэрээ байгуулсан:

Норовлин сум (дүүрэг) -ын
Засаг дарга

П.Алтангэрэл


Тамга тэмдэг

"Сэнжит бураат" нөхөрлөлийн

ахлагч 

Б.Оржилсайхан

Тамга, тэмдэг



Хаяг: Хэнтийн аймгийн Норовлин сум

Утасны дугаар: 96111288